



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/196

Хужирт сум

Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ын 11.4 дэх заалт, Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны "Сумын газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөө батлах тухай" 8/11/4 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 5-р багийн нутаг Гуа хороолол, төрийн албан хаагчдын орон сууцны ард байрлах 3000 м.квд газрыг Төв аймаг, Зуунмод, 4-р баг, Зүүндэлгэр, аб гудамж, 8 тоот хаягт оршин суугч Балдоржийн Дэлгэрмаа (НЮ87121360)-д 5-8 давхар нийтийн орон сууцны газар зориулалтаар (30 жил)-ийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.
2. Газар эзэмших гэрээ байгуулан төлбөрийг улирал бүр тооцон хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Ц.Нямдорж)-д даалгасугай.
3. Захирамж гарснаас хойш 90 хоногийн дотор байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, түүх археологийн судалгаа хийлгэхийг Балдоржийн Дэлгэрмаа (НЮ87121360)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.БАТБАЯР

622301393

D:Alban bichig;Zahiramj 2023